

“МУЗЕЙН НЭЭЛТТЭЙ ӨДРҮҮД” АЯНЫ ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.03.10

Дархан-Уул аймаг

Монгол орон даяар 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдруүдэд зохион байгуулагдсан “МУЗЕЙН НЭЭЛТТЭЙ ӨДРҮҮД”-д Дархан-Уул аймаг амжилттай оролцлоо. Нээлттэй өдруүдийн хугацаанд аймгийн Музейд нийт 1629 үзэгчид үйлчилж, 8 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

“МУЗЕЙН НЭЭЛТТЭЙ ӨДРҮҮД”-ийн хүрээнд аймгийн Соёл, урлагийн газрын зохион байгуулсан үйл ажиллагаа:

СУРТАЛЧИЛГАА:

2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдруүдэд зохион байгуулагдсан “МУЗЕЙН НЭЭЛТТЭЙ ӨДРҮҮД”-ийн хүрээнд Дархан-Уул аймгийн Музейн фото зураг, ажиллах цагийн хуваарь, холбогдох утасны дугаарыг нээлттэй гаргасан постерийг Соёлын яамнаас ирүүлсэн брэндбүүкийн дагуу бэлтгэн олон нийтэд сурталчиллаа.



ДАРХАН ХОТЫН НЭВТЭРХИЙ ТОЛЬ БҮТЭЭХ АЖЛЫН ЯВЦТАЙ ТАНИЛЦАХ
Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Дарханы нэвтэрхий толь” ном бүтээх судалгааны ажлыг эхлүүлэх” заалтын хүрээнд аймгийн Музейгээс эрхлэн Дархан хотын уугуул иргэд болон тус хотын бүтээн байгуулалтад оролцож явсан 120 гаруй ахмадуудтай уулзаж 1000 гаруй гэрэл зураг, товч намтар, дурсамж судалгааны материал цуглувуж байна. “Дарханы нэвтэрхий толь” бүтээх ажлын явцтай аймгийн Соёл, урлагийн газрын дарга, мэргэжилтнүүд танилцаж тус номонд Дархан-Уул аймгийн түүх, алдартнуудын мэдээллийг орхигдуулахгүй байх, олон нийтэд мэдээлэл хүргэж тэднээс мэдээлэл цуглувулахад хамтран ажиллах зэрэгт анхаарахыг зөвлөв. Номын эх бэлтгэл 90 гаруй хувьтай үргэлжилж байна гэж аймгийн Музейн дарга Д.Жамбалдорж ярьлаа.

A photograph showing a group of six people in a museum setting. In the foreground, a woman in a red dress is looking down at several open historical documents spread out on a wooden table. Next to her, another woman in a white dress is also examining the documents. In the background, three more individuals are standing and observing the display. The room has traditional Mongolian murals on the walls and a large blue banner at the top with text in Russian and English. A small circular logo for the "Museum of the People's Government" is visible in the bottom right corner.

Мөн “Эх орныхоо өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, бахархах, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх” зорилготой **“ИЛГЭЭЛТИЙН ЭЗЭД”** төслийн хүрээнд хуучны шашин, угсаатны эд зүйл, хуучны тоглоом, гитар, сурагчийн форм, гэр ахуйн эд зүйлс, тоног төхөөрөмж зэргийг Музейд хадгалуулснаар илүү үнэ цэнэтэй, үеийн үед таны нэрээр дуурсагдан хадгалагдаж, өнө удаан жил хойч үед өвлөгдөн, сурталчилагдах, тодорхой шалгуураар, шаардлага хангасан эд зүйлсийг журмын дагуу үнэ тохирч худалдан авах тухай **уряалгыг** олон нийтэд нийтэлсэн. Илгээлтийн эзэд булантай танилцлаа.



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын Сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ-ний 4.7 дахь заалт, дөрөвдүгээр хавсралтын 4.20 дахь заалт, зургаадугаар хавсралтад тусгагдсан “МУЗЕЙ, НОМЫН САНГИЙН ЦОГЦОЛБОР”-ын барилгыг улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэх ажил 30 гаруй хувьтай явагдаж байна.



“МУЗЕЙН НЭЭЛТТЭЙ ӨДРҮҮД”-ийн хүрээнд аймгийн Музейд зохион байгуулсан үйл ажиллагаа:

1. “МИНИЙ МЭДЭХГҮЙ НЭРШИЛ” контент


Тус нэвтрүүлгээр Дархан хотын иргэдээс Дархан хотын байршил газраас сонгон тухайн газрыг яагаад ийм нэртэй болсон тухай түүх, нэрлэсэн тухай асуулт хариултын 2 удаагийн цуврал нэвтрүүлэг бэлтгэн цахим хуудсаараа дамжуулан иргэд олон нийтэд мэдээллээ.

Дархан-Уул Аймгийн Музей
5d
#МузейҮзэхГое
#музеинээлттэйөдөр
“Миний мэдэхгүй нэршил” цахим контент№01
Эх оронцдын өдрийг тохиолдуулан Дархан хотын түүх, соёлыг нийтэд хүргэх “Миний мэдэхгүй нэршил” танин мэдэхүйн асуулт-хариултын цахим контентыг цувралаар хүргэх байна.
Өнөөдрийн асуулт? Хуучин Дарханы 18-ын буудлыг яагаад 18-ын буудал тэж нэрлэсэн юм бол? ... See more

дархан-уул аймгийн музей
2d
#МузейҮзэхГое
#музеинээлттэйөдөр
“Миний мэдэхгүй нэршил” цахим контент№02
Дархан хотын түүх, соёлыг нийтэд хүргэх “Миний мэдэхгүй нэршил” танин мэдэхүйн асуулт-хариултын цахим контентыг цувралаар хүргэх байна.
Өнөөдрийн асуулт? Древэнь гэж яагаад нэрлэдэг вэ?
Дараагийн удаа та бүхэн Дархан хотын ямар нэршилийн талаар илүү тодорхой мэдмээр байгаагаа коммент үлдээхийг хүсж байна. Баярлалаа. Тайлбарыг Дархан хотын унаган иргэн, 12 дугаар багийн ахмад настан Ж.Баярхүү

2. “БИД МАРТАХГҮЙ” цахим контент

Эх орончдын өдрийг тохиолдуулан Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй “ХУВЬСГАЛТ ТЭМЦЛИЙН АХМАД ЗҮТГЭЛТНҮҮД”-ийн гэрэл зургуудаар “БИД МАРТАХГҮЙ” цахим контент бэлтгэн Дархан-Уул аймгийн Музейн цахим хуудсаар толилуулав. Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн нь Улс орныхоо тусгаар тогтнолын төлөө тэмцэж явсан ахмад дайчитдай дүйцэхүүц шагнал юм.



3. Дархан-Уул аймгийн Музейд “ЧИНГИС ХААНЫ ЭШ ХӨРӨГ ЗАЛАХ ЁСЛОЛ”-ыг зохион байгуулав. Тус ёслолд аймгийн музейн хамт олон, Орхон, Хонгор, Шарын гол сумдын орон нутаг судлах танхимиын албан хаагчид, мөн Сэлэнгэ аймгийн “Алтанбулагийн Хувьсгалын Музей”-н хамт олон оролцлоо.




4. “МУЗЕЙН ЁС ЗҮЙ” сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтаар музей, соёлын өвийн ажилтан нь:

- Музейд хэрэгцээтэй үндсэн чадвар юу вэ?
- Музейн ёс зүй гэж бий юу?
- Хэрхэн яаж музейн үзэсгэлэн, тайлбар, харилцаа, цуглуулга, судалгааны ажилд мэргэжлийн ёс зүйгээр хандаж, харьцах вэ?
- Музейн ёс зүйн стандарт, дүрэм бий юу? байдаг бол бидний ажлын орчинд?
- Орчин үеийн Музейн мэргэжилтнүүдийн ур чадвар, хандлага юу болох? Үүнд

мэргэжлийн ёс зүйг хэрхэн уялдуулан ажиллах зэрэг сэдвүүдээр сургалт, асуулт, хариулт хэлэлцүүлгийг СУИС-ийн С.Лувсанванданы нэрэмжит Соёл, урлаг судаллын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С.Энхнаран удирдан явууллаа.

Сургалтад Дархан-Уул аймгийн Музей, Орхон, Хонгор, Шарын гол сумдын Орон нутаг судлах танхимын ажилчид, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн Музейн ажилчид зэрэг 30 гаруй хүмүүс оролцлоо.




5. "БИД МАРТАХГҮЙ" СЭДЭВТ ЛЕКЦ

Аймгийн Музейн захирал Д.Жамбалдорж Дархан хотод амьдарч байсан ХТАЗ, 1939, 1945 оны дайнд оролцож байсан ахмад дайчдын тухай "Бид мартахгүй" сэдэвт лекцийг Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн Ж.Оюун багштай 9-6, Д.Солонго багштай 9-9 ангийн 60 гаруй сурагчдад уншлаа.



6. “БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР”

Музейн үзэгчдэд зориулан үнэ төлбөргүй “МАНДАЛА АРТ” зурах боловсролын хөтөлбөрийг нээлттэй зохион байгуулсан.



“МУЗЕЙН НЭЭЛТТЭЙ ӨДРҮҮД”-ийн хүрээнд аймгийн Музейн фото зургийг shinebatuv@gmail.com хаяг руу илгээж, үзэгчийн тоон мэдээллийг info@culture.gov.mn, purevsuren.b@moc.gov.mn цахим хаяг руу мэдээлж ажиллалаа.



№	Үзэгчид	Насанд хүрэгчид	Оюутан	Хүүхэд	Нийт
1	3 дугаар сарын 1	10	0	37	47
2	3 дугаар сарын 2	96	16	120	232
3	3 дугаар сарын 3	156	0	279	435
4	3 дугаар сарын 4	102	0	289	391
5	3 дугаар сарын 5	175	0	349	524
НИЙТ		539	16	1074	1629

Мөн үйл явцын мэдээ мэдээллийг аймгийн Соёл, урлагийн газрын цахим хуудас, Музейн цахим хуудсуудаар тогтмол мэдээлж ажиллалаа.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
СОЁЛ, УРЛАГИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Б.Чинбилэг*

ХЯНАСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.СОЁЛ-ЭРДЭНЭ